

ЯПОНЫ “RESILIENCE”: “КОВИД-19 ЦАР ТАХАЛ”-ЫН СУРГАМЖ

С.БАТТУЛГА

МУИС, ШУС-ийн Ази судлалын
Тэнхимийн доктор (Ph.D), профессор

Товч агуулга:

1. Оршил: “Resilience” яагаад чухал вэ?
2. Японы “Resilience”
3. “Ковид-19” цар тахал” ба Японы сургамж
4. Дүгнэлт: “Үндэсний Resilience”

Түлхүүр үгс: *Resilience* (Даван туулах чадвар), Японы *Resilience*, “Ковид-19 цар тахал”-ын сургамж, Үндэсний *Resilience* (*National Resilience*)

1. Оршил: “Resilience” яагаад чухал вэ?


Өнөөгийн дэлхий ертөнц, хүн төрөлхтний өмнө урьд өмнө төсөөлөгдөж байгаагүй “шинэ эрсдэл”-үүд бий болж (*Ulrich Beck*, 1986, 1992, 1994, 1998, 2000, 2009), зарим тохиолдолд ердийн зүйл “хэрээс хэтэрч” (*Francis Fukuyama*, 2020(2018):215) байгаа тухай нөлөө бүхий судлаачид сануулсаар байна. “Ковид-19 цар тахал” дэгдсэний дараа, “дэлхийн буруу тогтолцоо, ялангуяа, нийгмийн хуваагдал, шударга бус байдал, нэгдмэл бус байдал, дэлхийн засаглал болон манлайллын хямрал нь одоо урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр ил болж” байна гэж судлаачид дүгнэжээ. (Клаус, Тьерри, 2021(2020):1, 172) Ямартай ч “Ковид-19 цар тахал” болон “Орос-Украины хямрал”-аас үүдсэн дэлхий дахины өнөөгийн нөхцөл байдал нь “Хүний аюулгүй байдал”, “Улс үндэстний аюулгүй байдал” амин чухал тулгамдсан асуудал болохыг батлан харуулж байна.

Үүнээс үүдэн хүн төрөлхтөн, улс үндэстнүүдийн хувьд гэнэтийн томоохон эрсдэлд бэлэн байх, эрсдэл хямралыг сөрөн зогсох, зохицуулах, даван туулах явдал нэн чухал болж байна. Үүний тулд улс үндэстнүүд “*Resilience*” (Даван туулах чадвар (С.Баттулга))-таа анхаарал хандуулахын зэрэгцээ “Үндэсний *Resilience*” (*National Resilience*, Үндэсний даван туулах чадвар)-аа хөгжүүлэх шаардлага, сорилттой тулгарч байгаа бөгөөд үүнд олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх болно гэж үзэж байна.

"Resilience"¹ гэдэг ойлголт 1970-аад оны үеэс анх сэтгэл судлал, биологи, экологийн салбарт "хуучин байдалдаа эргэж орох чадвар" гэх утгаар түлхүү хэрэглэгдэж эхэлжээ. Харин орчин үед зөвхөн эдгээр салбараар хязгаарлагдахаа больж, гамшиг судлал, эдийн засаг, нийгэм, улс төр гэх мэт салбар, макро түвшинд олон янзын утгаар хэрэглэгдэх болжээ.²

Энэ ойлголтын талаар тогтсон нэг тодорхойлолт байхгүй ажээ. Гэхдээ онолын хувьд ерөнхий байдлаар авч үзвэл "тэнцвэрээ алдаж унахгүй байх" нөхцөл байдлыг "Resilience" гэж ойлгож болох бөгөөд Resilience нь "тогтвортой байдлын угтвар нөхцөл" болно гэж хэлж болно. (Зураг 1)³ Мөн "гамшиг гэх зэрэгт өртсөн ч уян хатан байдлаар сэргэх чадварыг илэрхийлнэ. Энэ нь гамшгаас хамгаалах ойлголтоос ч өргөн ухагдахуун бөгөөд нийгэм бүхэлдээ хүчин чадлаа чиглүүлж сайжруулах ёстой улс орны газар нутаг, хот төлөвлөлт зэргийг бүхэлд нь хамруулсан цогц ойлголт. Resilience-ийг сайжруулахын эцсийн зорилго бол урт хугацаанд тогтвортой байдлыг хангаж, хүн төрөлхтний аз жаргалыг бодитой болгох явдал."⁴ гэж үзэж болохоор байна.

Зураг 1. "Resilience" ба "Тогтвортой хөгжил"-ийн холбоо хамаарал



¹ Энэ үгийг монгол хэлэнд "уян хатан, харимхай чанар; мөн байдал; тэсвэр хатуужил; хурдан сэргэх, сэргэн хөгжих, дасан зохицох, даван туулах чадвар; явц; үр дүн" гэх зэрэг олон янзын утгаар хөрвүүлж болно. Судлаач миний бие энэхүү өгүүлэлдээ дээрх олон утгыг тоймлон "Даван туулах чадвар" гэдэг үгээр илэрхийлж байгаа болно. Цаашид оновчтой зөв үгийг олж хэрэглээний эргэлтэнд оруулах шаардлагатай. (С.Баттулга)

² 村木良孝「レジリエンスの統合的理解に向けて」東京大学大学院教育学研究科紀要, 第55巻, 2015:281.

³ 林吉嗣・鈴木康弘2015:29.

⁴ Сүзүки Ясүхиро "Нийгмийн Resilience-ийг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтарсан судалгааны үүрэг", XXI зууны Монгол-Японы стратегийн түншлэл: Байгаль орчин, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа, Монголын Япон судлалын нийгэмлэгийн хурлын эмхэтгэл, 2016, 57-69.

Судлаач миний бие (С.Баттулга) эрдэм шинжилгээний хэд хэдэн өгүүлэлдээ энэ сэдвийн тухай авч үзсэн бөгөөд, түүндээ Монгол Улс “Хүний аюулгүй байдал, даван туулах, дасан зохицох чадвар (*Resilience*), Ногоон бодлогод тулгуурласан “Гурван тулгуурт дипломаси (дипломат үйл ажиллагаа)”-г “Гуравдагч хөршийн бодлого”-ын үндсэн чиглэл болгох нь зүйтэй” гэсэн саналыг дэвшүүлсэн. (С.Баттулга, 2021:10-29(26)) Тухайлбал, Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд, энэ чиглэлээр арвин туршлагатай Япон улсын туршлагыг судлах, нягт хамтран ажиллах, зарим сайн туршлагыг нэвтрүүлэх боломжтой гэсэн дүгнэлт хийж байсан билээ. (С.Баттулга 2018:147-154)

Дээрх дүгнэлтдээ тулгуурлан энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд, “Ковид-19 цар тахал”-аас япончууд ямар сургамж авсныг тодруулах замаар Японы “Үндэсний *Resilience*”-ийг нягтлах зорилго тавих болно. Үүний тулд эхлээд, Японы *Resilience*-ийн талаар авч үзнэ. Түүний дараа зарим нэг судлаачийн судалгааны дүгнэлтэд тулгуурлан, Ковид-19 цар тахлын үр дүнд япончууд ямар сургамж авч буй талаар танилцуулна. Эцэст нь, Монгол Улс Япон улсын туршлагаас сургамж авч, “Үндэсний *Resilience*”-ээ сайжруулахад онцгой анхаарах шаардлагатай гэсэн санааг дэвшүүлэх болно.

2. Японы “Resilience”

Япончууд газар хөдлөлт, цунами, галт уулын дэлбэрэлт, хүчтэй аадар бороо гэх зэрэг байгалийн гамшиг, эрсдэлтэй байнга нүүр тулж ирсэн бөгөөд энэ талаар асар их туршлага хуримтлуулсан, байгалийн томоохон эрсдэлд харьцангуй бэлтгэгдсэн ард түмэн юм. Тэд боловсрол, соёл, менежментийг багтаасан өөрийн гэсэн цогц “гамшгийн (тухай) мэдлэг”-ийг бий болгосон төдийгүй тэрхүү уламжлалт мэдлэг, туршлагадаа тулгуурлан *Resilience* чадвараа сайжруулж, улмаар “Үндэсний *Resilience*” (*National Resilience*)-аа бэхжүүлж ирсэн гэж дүгнэж болно.

Японы Академик Хурал (日本学術会議)-аас 2006 онд байгуулагдсан эрдэмтдийн Байгалийн гамшгийн аюулгүй, амар амгалан нийгмийн суурийг цогцлоон байгуулах хороо (自然災害に対して安全 安心な社会基盤の構築委員会) 2007 онд бодлогын санал боловсруулж, дараах үндсэн 11 зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- 1) Аюулгүй, амар амгалан нийгмийг байгуулах концепцийн өөрчлөлт хийх
- 2) Нийгмийн суурийг бий болгох зүй зохистой стандарт бий болгох
- 3) Улсын газар нутгийн тогтолцоог дахин зохион байгуулах
- 4) Хатуу болон Зөөлөн бодлогыг хослуулах
- 5) Бүс нутгийн сул талыг дахин үнэлэх, ойлгох

- 6) Улс, орон нутгийн өөрийгөө удирдах байгууллагын нэгдсэн бодлого гаргах
- 7) "Гамшгийг ухамсарлан ойлгосон нийгэм"-ийг байгуулах
- 8) Гамшгаас хамгаалах суурь боловсролыг бэхжүүлэх
- 9) NPO, NGO байгууллагыг бойжуулах, дэмжлэг үзүүлэх
- 10) Гамшгийн салбарт олон улсын дэмжлэг үзүүлэх
- 11) Гамшгийг бууруулах тогтвортой стратеги, тогтолцоог бий болгох, гэжээ.

Эрдэмтдийн дэвшүүлсэн дээрх концепц нь "богино хугацааны эдийн засгийн үр ашиг"-аас илүүтэй "аюулгүй, амар амгалан нийгэм"-ийг байгуулах асуудлыг нэн тэргүүнд чухалчилсан парадаймын өөрчлөлт хийх шаардлагатай байгааг илэрхийлсэн төдийгүй, гамшгийг даван туулах чадавх сул байгаа явдлыг тухайн асуудал нийгэм, улс орны газар нутгийн тогтолцоо, зохион байгуулалтыг бүхэлд нь хамарч байгаатай холбоотой гэж үзсэнээрээ чухал болжээ. Түүний зэрэгцээ аюулгүй гэдэгт итгэж ирсэн орчин үеийн нийгэм (хот) өмнөхөөсөө илүү хэврэг болж байгааг олон нийтэд зарласан үйл явдал болсон, гэж судлаачид дүгнэжээ. (林 2016:19-20)

Япончууд асар их хохирол амссан 2011 оны Зүүн Японы газар хөдлөлт (東日本大震災)-ийг Япон улсын Засгийн газар "тооцоолж байснаас хэтэрсэн" гамшиг болсон гэж тайлбарласан. Харин үүнийг, улс орныг хамарсан бодлогын өөрчлөлт хийх шаардлагатай байгааг онцолж хэлсээр атал япон "хүчин мөхөцсөн" гэж зарим судлаач дүгнэжээ. (Richard J. Samuels, 2013) Япон улсын Засгийн газар энэхүү газар хөдлөлтийн дараа улс үндэстнийхээ чадварыг сайжруулах асуудлыг дахин цогцоор авч үзэх шаардлагатай гэж дүгнээд, "Үндэсний Resilience" бодлогыг боловсруулсан байна. 2014 онд Япон улсын Сайд нарын зөвлөл уг үндэсний бодлогын хүрээнд "Улс орны газар нутгийг хүчжүүлэн тэсвэржүүлэх үндсэн төлөвлөгөө"-г баталжээ. Уг баримт бичигт:

"Зүүн Японы их газар хөдлөлтөөс авсан сургамжид тулгуурлавал, эргэлзэх зүйлгүйгээр хамгийн муу нөхцөл байдлыг нэн түрүүнд тооцоолж, өнөөг хүртэл явцуу утгаар хандаж ирсэн "гамшгаас хамгаалах" хүрээг давж, улс орныхоо газар нутаг, аж үйлдвэрийн бодлогыг бүхэлд нь хамруулсан цогц бодлогыг (товчлов) хэрэгжүүлж бэлэн байх шаардлагатай (товчлов). Тиймээс, ямар ч гамшиг тохиолдсон бай 1) Хүний амь насыг дээд хэмжээнд хамгаалах, 2) Улс орон болон нийгмийн чухал шаардлагатай тогтолцоо ямар нэгэн хохирол амсалгүй тогтвортой байх, 3) Ард түмний өмч болон нийтийн барилга байгууламжид учрах хохирлыг хамгийн бага

хэмжээнд барих, 4) Хурдтай сэргээн босгох явдлыг гол зорилго болгож, "хүчтэй", "уян хатан", "аюулгүй, амар амгалан" улс орны газар нутаг, бүс нутаг, эдийн засаг нийгмийг бүтээн байгуулахад чиглэсэн "Үндэсний *Resilience (National Resilience)*"-ийг бэхжүүлэх болно." (Япон улсын Сайд нарын зөвлөл, 2014) гэж тодорхойлжээ.

Эндээс харахад, Япон улсын Засгийн газар уг "Үндэсний *Resilience*" бодлогоо улс орныхоо хөгжлийн ерөнхий бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан цогцоор авч үзэж, өндөр ач холбогдол өгч байгаа нь тодорхой байна. "Хүн хүч, эрх зүйн орчин, өндөр технологи хангалттай сайн байлаа ч байгалийн гамшгийн аюулыг зогсоох боломжгүй" гэдгийг япончууд маш сайн ойлгож ухамсарладаг. (Сүзүки 2017:6) Өнөө үед, *Resilience*-ийг сайжруулахад уламжлалт мэдлэг, хүрээлэн буй орчиндоо зохицон амьдрах, уян хатан байх чадварын зэрэгцээ орчин үеийн технологид суурилсан мэдээллийн санг бүрэн дүүрэн ашиглах явдал маш чухал. Тиймээс, Япон улс даван туулах чадвараа сайжруулахдаа өнөөг хүртэл чухалчилж ирсэн барилгын хатуу бэхжилт, бат бөх зам, тээврийн дэд бүтэц, зузаан төмөр хамгаалалтын хана гэх мэт "хатуу" (*Hard*) талыг чухалчлахаас илүүтэй тогтвортой, тэсвэр тэвчээртэй, түргэн хугацаанд сэргэх чадвартай хүн, нийгмийн сэтгэлзүй, бодлого, менежмент гэх мэт "зөөлөн" (*Soft*) талд түлхүү анхаарал хандуулж, хандлагаа өөрчлөхийг зорьж байна.

3. "Ковид-19" цар тахал" ба Японы сургамж

"Ковид-19" цар тахал улс орнуудын аливаа гэнэтийн томоохон эрсдэлд бэлэн байх, даван туулах чадварыг сорьсон томоохон "гамшиг" боллоо. Энэ нь хүн төрөлхтөн гэнэтийн томоохон эрсдэлд бэлэн байх "шинэ зохион байгуулалт"-ыг хэрэгжүүлэх шаардлагатай (Клаус, Тьерри, 2021(2020)) болж буйг илтгэн харуулж байна. Хүн төрөлхтнийг хамарсан энэхүү цар тахлыг амжилттай даван туулж яваа улсын нэг бол Япон улс юм. Тухайлбал, япон дахь цар тахлын халдвар авсан иргэн, нас барсан иргэдийн тоон үзүүлэлтийг хөгжсөн орнуудын үзүүлэлттэй харьцуулж үзвэл хамгийн бага үзүүлэлттэй байгааг зарим судалгаанаас харж болно. (График 1, 2 (*Johns Hopkins University*, 2022)) Мөн халдварын эрсдэл хамгийн өндөр бүртгэгдсэн байдлыг харахад, 2022 оны 2 дугаар сарын эхний 7 хоногт 104483 хүн халдвар авсан гэж бүртгэгджээ. (График 3, *Shobayashi Tokuaki*, 2022)

График 1. Улс орнуудын халдвар авсан хүний тоо
(7 хоног тутмын дундаж, 1 сая хүн тутамд)
(Эшлэл: Johns Hopkins Univ. CSSE Covid-19 Data)




図3 各国の直近の新規感染者数（7日間移動平均・人口100万人対）

График 2. Улс орнуудын цар тахлын улмаас нас барсан хүний тоо
(7 хоног тутмын дундаж, 1 сая хүн тутамд)
(Эшлэл: Johns Hopkins Univ. CSSE Covid-19 Data)





図4 各国の直近の新規死亡者数（7日間移動平均・人口100万人対）

График 3. Японы цар тахлын халдвар авсан хүний тоо
(2022 оны 7 сарын байдлаар, Эшлэл: Shobayashi Tokuaki, 2022)



Ковид-19 цар тахал дэгдсэн даруйд хилээ хаах, хөдөлгөөнийг хязгаарлах, нөхцөл байдлыг оношлох, олон нийтийг мэдээллээр түргэн шуурхай хангах, “онц байдал” тогтоох тухай Япон улсын Засгийн газрын шийдвэрүүд нь эрсдлийг бага түвшинд тогтоон барихад нөлөөлсөн нь тодорхой. (正林督章, 2022:283-284). Засгийн газраас эрүүл мэнд, аялал жуулчлал, худалдаа, зоогийн газар, зугаа цэнгэл, зочид буудлын салбар хүнд байдалд орсныг харгалзан, хариу арга хэмжээ болгож хямралыг даван туулахад туслах зорилгоор тодорхой санхүүгийн дэмжлэгийг компани болон гэр бүл, тусгай дэмжлэг шаардлагатай иргэдэд шат дараатайгаар олгож байжээ. Түүнээс гадна, цар тахлын халдварт өртөж тусламж авах нэн шаардлагатай байгаа иргэн, гэр бүл, компанид зориулж амьдрах, амьжиргаагаа хамгаалах, ажлын байр бий болгох, түүнийг хамгаалах, компанийн үйл ажиллагааг хамгаалах чиглэлээр санхүүгийн дэмжлэг бүхий цогц хөтөлбөрүүдийг нээлттэй танилцуулж, хэрэгжүүлсэн байна. Мөн Япон улсын Засгийн газар вакцины хангалтад анхаарч, вакциныг гарган авах судалгаа, технологийн үйл ажиллагаанд тодорхой санхүүжилтийг гаргаж, өөрийн гэсэн вакцинтай болох ажлыг шуурхайлж байв. Япончууд гадаад улсад үйлдвэрлэсэн вакцинд нэн болгоомжтой хандаж байв. Энэ нь гаднын вакциныг яаран хийлгэхийг хүсэхгүй байх, төр, засаг нь иргэдийгээ вакцинжуулалтад хүчээр шахан хамруулахгүй, вакцинжуулах ажлыг зохион байгуулахдаа иргэдийнхээ хүсэлтийг хүндэтгэн үзэх гэх зэрэг хандлагаас тодорхой харагдаж байгаа юм. Дээрх

зарим хандлага нь япон дахь вакцинжуулалт харьцангуй удаашралтай явагдахад нөлөөлсөн гэж үзэж болох юм.

Эрүүл мэндийн талаарх япончуудын мэдлэг ухамсар сайн, иргэд нь эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдсан байхаас гадна эрт илрүүлгийн шинжилгээ оношилгоонд тогтмол хамрагдаж заншсан байдаг. Энэ нь цар тахлын үеийн эрүүл мэндийн хүндрэлийг даван туулах, урьдчилан сэргийлэх, иргэд өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг хянахад эерэг нөлөө үзүүлсэн гэж хэлж байна. Япон улсын Засгийн газар 2021 оны 10 дугаар сард “онц байдал”-ын зэрэглэлийг бууруулж, цуцалсан. Гэвч хүн бүр маскаа үргэлжлүүлэн хэрэглэж байхыг анхааруулсаар байгаа юм.

Японы зарим судлаачийн судалгаанд тулгуурлан, Ковид-19 цар тахлаас япончууд ямар сургамж авч байгаа, цаашид юунд анхаарахыг сануулж байгаа талаар одоо авч үзье. (正林督章, 2022:283-290). Үүнийг танилцуулснаар, монголчууд бид японы туршлагаас суралцах, бидний зүгээс авч буй сургамж тэднийхээс зөрүүтэй байна уу үгүй, бид цаашид юунд анхаарах ёстой вэ гэдгийг нягтлах ач холбогдолтой юм. Үүнд:

Цар тахлын үед хамгийн түрүүнд авах арга хэмжээ:

1. Гадаад улсад халдвар дэгдсэн тохиолдолд тухайн улсад байрлаж буй Элчин сайдын яам, судлаачид, Япон-Хятад-БНСУ-ын Даатгалын сайд нарын уулзалтын сүлжээ, ДЭМБ гэх зэрэг олон талын арга замыг ашиглан маш хурдтайгаар мэдээлэл цуглуулах, яамдын холбогдох хүмүүстэй мэдээллээ хуваалцах, ард иргэд, орон нутаг, эрүүл мэндийн холбогдох талд мэдээлэл өгөх
2. Хамгийн муу нөхцөл байдлыг тооцоолсон анхны хариу арга хэмжээ
3. Түргэн хугацаанд мэргэжилтнүүдийн нэгж бүтцийг байгуулах, үндсэн хандлагаа тодорхойлох
4. Боломжит хэмжээнд мэргэжилтнүүдийн саналыг цуглуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого шийдвэр гаргах.

Зохион байгуулалт, удирдлага:

1. Түргэн хугацаанд эрүүл мэндийн эрсдлийн хяналт зохицуулалтын хурлыг зохион байгуулах, мэдээлэл хуваалцах
2. Түргэн хугацаанд Эрүүл мэнд, хөдөлмөрийн яамны ажлын штабыг байгуулах
3. Түргэн хугацаанд Засгийн газрын ажлын штабыг байгуулах
4. Ажлын хэмжээнд уялдуулан ажлын штабуудад ажиллах хангалттай хүний нөөцийг зохион байгуулах, шаардлагатай цаг үед тохируулан хүний нөөцийн ээлжийг зохион байгуулах, ажилтнуудыг тодорхой хугацаанд ажиллуулах, шаардлагатай тохиолдолд гаднаас хүний нөөцийг татах боломжтой байх

5. Халдвар хамгааллын горимыг хангасан хангалттай зайтай ажлын өрөөнүүд бэлдэх
6. Яам, газруудын тус бүрийн хариуцах үүргийг тодорхой болгох
7. Түргэн хугацаанд мэргэжилтнүүдийн нэгж бүтцийг байгуулах
8. Мэргэжилтнүүдийн нэгж бүтцэд багтах хүний тоо хэт олон биш, мэргэжилтнүүдийг халдвар төдийгүй эрүүл мэндийн тогтолцоо, эдийн засаг зэрэг олон талт салбараас сонгож оруулах
9. Мэргэжилтнүүдтэй таатай харилцах
10. Шийдвэр гаргах процесс хялбар байх

Хил дээр авах арга хэмжээ:

1. Халдвар авсан эсэхийг яаралтай оношилж тогтоох
2. Эрүүл мэндийн дагаж мөрдөх зохион байгуулалтыг яаралтай хийх, мэдээллийн технологийг ашиглах
3. Ирж буй иргэдийг байлгах байрыг хангалттай хэмжээгээр бэлдэх
4. Халдварын тархалтын нөхцөл байдалтай уялдуулан хил нэвтрүүлэхийг хориглох улс, бизнесийн чиглэл, оршин суух газрыг тогтоох
5. Оношилгооны газрын шинжилгээ хийх зохион байгуулалтыг яаралтай бүрдүүлэх (шинжилгээний багаж хэрэгсэл, хүний нөөц)
6. Олон хэлээр нэвтрэлцэх нөхцөлийг яаралтай бүрдүүлэх
7. Мутант омогт хариу арга хэмжээ хурдан авах

Тандалт:

1. Мэдээллийг яаралтай цуглуулж, боломжит хэмжээнд өвчтөний дүр төрхөд ойр халдварын жишээний тодорхойлолт гаргах, мэдлэгтэй болох
2. Факс болон гараар бичих ажил үйлдлээс зайлсхийж, мэдээллийн технологийг ашиглаж, цахимаар шивэх софтыг богино хугацаанд гаргах, цар тахал дэгдэхээс өмнө нэвтрүүлэх
3. Шивэх хүнийг бэлдэх, түүний эдийн засгийн хөшүүрэг, эсвэл урамшуулал өгөх
4. Мэдэгдэх стандартыг заавал мэдүүлэх, ялангуяа шинжилгээний хариу сөрөг байгаа ч сэжигтэй хүн заавал мэдэгдэх үүрэгтэй болохыг мэдүүлэх
5. Шивж оруулах зүйлийн гарчгийг нарийн тооцож гаргах, өвчтөний хүндрэл, нас баралт зэрэг эрүүл мэндийн мэдээллийг оруулахад нэгтгэн харах боломжтой байдлаар системийг сайжруулж байх

Эпидеомологийн идэвхтэй судалгаа:

1. Эпидеомологийн идэвхтэй судалгаа явуулах газрыг яаралтай тогтоох, мэдэх

2. Орчны судалгаа хийхийг хөхиүлэн дэмжих
3. Улсдаа мэдээлэх үүрэгтэй болох, цахимаар мэдээлэх боломжтой болохыг мэддэг байх
4. Судалгаа явуулах эрүүл мэндийн төвийн ажилтны нөөцийг бэлдэх, ердийн үед бэлтгэл сургууль хийж байх
5. Мэдээллийн технологийг ашиглаж хөөн тогтоох системийг богино хугацаанд бүтээх, нэвтрүүлэх, холбогдох хүнийг бэлдэн сургах

Эрүүл мэндийн төвийн зохион байгуулалт:

1. Ердийн цаг үеэс яам, тамгын газар, хот дүүрэг, тосгоны зүгээс дэмжлэг үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх (дэмжлэг үзүүлэх боломжтой хүний нэрийг урьдчилан тогтоох), хувийн хэвшилд даалгах, эмч, сувилагчийн холбоо гэх мэт гаднаас боловсон хүчин авах бэлтгэл хангах
2. Ердийн үед асран сувилах бэлтгэл сургуулилт хийж байх, түр хугацаанд сонгон ажиллуулах замаар харилцаа тогтоох
3. Ердийн үед үйл ажиллагааг таслахгүй явуулах төлөвлөгөө (Business Continuity Plan) гаргах (үйл ажиллагааны дэс дараа)
4. Шаардлагатай үед дээрх дэмжлэг үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, ээлжээр ажиллах нөхцөлийг хангах
5. Халдвар их тархсан үеийн эрүүл мэндийн төвийн шинжилгээний орчин нөхцөл, хэвтэн эмчлүүлэх, гарах зэрэг эмчилгээний орчныг бүрдүүлэх

Оношилгоо шинжилгээний орчин:

1. Хувийн хэвшлийн шинжилгээний байгууллагын PCR гэх мэт шинжилгээний чадавхыг цаг үргэлж мэдэж байхын зэрэгцээ шинжилгээний орчин нөхцөлийг хурдан хугацаанд хангах боломжтой байхыг хэлсэн байх
2. Шинжилгээ зах зээлийн зарчмаар хийгдэх бөгөөд аль болох хурдан хугацаанд даатгалд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх
3. Хурдан хугацаанд PCR шинжилгээг улсын бүх орон нутгийн эрүүл мэндийн судалгааны хүрээлэн, шинжилгээний төвд хийх боломжтой байх орчин нөхцлийг бүрдүүлэх
4. Эрүүл мэндийн төвөөр дамжилгүй эрүүл мэндийн байгууллагын шийдвэрээр шинжилгээ оношилгоо хийх тогтолцоог үе шаттайгаар бүрдүүлэх
5. Антигенийн тоон болон чанарын шинжилгээг хурдан хугацаанд гаргах, нэвтрүүлэх
6. Шинжилгээний нарийвчлалыг хянах тогтолцоог бий болгох

7. Шинжилгээний хариу хуурамч эерэг, сөрөг гарч, мөн хязгаарлагдмал болохыг ард нийтэд таниулах

Эмчилгээний орчин нөхцөл:

1. Цар тахал дэгдэхээс өмнөх шатанд хот, мужууд дахь эмнэлгийн ор бэлдэх төлөвлөгөөг гаргах
2. Цар тахал дэгдсэний дараа хот, мужууд дахь эмнэлгийн ор бэлдэх төлөвлөгөөг гаргах (эмнэлгийн байгууллага хоорондын үүргийн хуваарилалтыг тодорхой болгох)
3. Эмнэлэгт хэвтэхийн өмнөх хүлээлгийн газар, түр эмнэлгийн байгууламж, хоноглох байгууламж гэх мэт эмнэлгээс өөр газарт эмчилгээний тогтолцоог бүрдүүлэх
4. Гэрээр эмчлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх
5. Төрийн байгууллага, эмнэлгийн байгууллага, эмнэлгийн холбогдох хүмүүс хоорондын харилцааг бэхжүүлэх
6. Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн холбогдох хүмүүст зориулсан санхүүгийн хангалттай дэмжлэг (Төсвийн дэмжлэг, эмчилгээний урамшууллын үнэлгээ)
7. Эрүүл мэндийн байгууллагын ажилтны халдвар авсан тохиолдлын сургууилт, халдварын мэргэжилтнийг сургах, бэлдэх
8. Цар тахлыг тооцоолсон гэнэтийн үед хэрэгцээ хэмжээгээр хэрэглэх маск, PPE, хиймэл амьсгалын аппарат гэх мэт эмнэлгийн тоног төхөөрөмж, PCR шинжилгээний эм бэлдмэл гэх мэтийг үйлдвэрлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, хуримтлуулах
9. Бусад улсын тусламжид найдалгүй хэрэгцээгээ хангахуйц дотоодын эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх газрыг бэлдэх

Эмчилгээний эм бэлдмэл:

1. Улс дотроо хурдан хугацаанд эм бэлдмэлийг гаргаж авах
2. Эм бэлдмэлийг хурдан хугацаанд хүлээн зөвшөөрөх
3. Эм бэлдмэлийг хурдан хугацаанд их хэмжээгээр бэлдэх
4. Орон нутагт эм бэлдмэлийг хүргэх тогтолцоог бүрдүүлэх
5. Үр дүн, аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг цуглуулах, мэдээлэх

Вакцин:

1. Вакцин гаргах судалгааны зардал бэлдэх
2. Вакцин гарган авахтай холбоотой сүүлийн үеийн технологийг нээх, мэдээлэл цуглуулах
3. Дотоодод хурдан хугацаанд нээж гаргах, олон улсын хамтарсан эмчилгээний туршилтад оролцох

4. Вакцины зөвшөөрлийг хурдан хугацаанд олгох
5. Вакциныг хурдан хугацаанд хангалттай хэмжээнд бэлдэх
6. Вакциныг хурдан хугацаанд нийлүүлэх төлөвлөгөөг тогтох, мэдээллээр хангах
7. Хот, муж, орон нутагт тарилгыг хурдан хугацаанд зохион байгуулах бэлтгэл хангах (хариуцаж буй газар хэлтсийн хүний нөөцийг бэхжүүлэх, тарилга хийх хүнийг бэлдэх)
8. Хязгаарлалтыг суллахтай холбоотойгоор тарилга хийх хүнийг бэлэн байлгах орчныг бүрдүүлэх
9. Бие даасан засаг захиргааны нэгж дэх вакцин тарилгын орчин нөхцөлийг хангахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг
10. Үр дүн, аюулгүй байдалтай холбоотой мэдээлэл цуглуулах, түгээх, ташаа мэдээллийг залруулах
11. Вакцинжуулалтын хувь хэмжээг дээшлүүлэхэд чиглэсэн урамшуулал олгох
12. Вакцины сөрөг хариу үйлдлийн талаарх мэдээлэл цуглуулах, мэргэжилтний үнэлгээ, нээлттэй тунгалаг байдлыг хангах
13. Эрүүл мэндийн хохирол амссан хүнийг авран хамгаалах тогтолцоог зохион байгуулах

Тайлан мэдээлэл, эрсдлийн харилцаа:

1. Хэрэгтэй цагт шаардлагатай мэдээллээр хангах
2. Веб сайт, постер гэх мэтээс гадна SNS зэрэг олон талт мэдээлэл сурталчилгааны хэрэгслийг ашиглан мэдээллээр хангах
3. Нэр хүндтэй хүнийг ашиглах зэргээр итгэл үнэмшил бүхий мэдээллээр хангах
4. Ард түмэнтэй эрсдлийн талаар харилцан ярилцах
5. Засгийн газрын талаарх шүүмжлэлт мэдээлэл, эсэргүүцэл бүхий мэдээллийг цуглуулах, үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээ авах.

Эндээс харахад, гэнэтийн томоохон гамшиг, эрсдлийг даван туулахад тухайн цаг үе дэх эрсдлийн менежмент, үйл ажиллагааны дэс дараалал, зураглал, хүний нөөцийн хангамж, чадавх, талууд (Засгийн газар, орон нутаг, мэргэжлийн холбогдох байгууллага, иргэн)-ын чиг үүрэг, хамтын ажиллагаа чухал болох нь тодорхой. Түүнээс гадна, гэнэтийн томоохон гамшиг, эрсдэл үүсэхээс өмнөх ердийн цаг үе дэх байнгын бэлэн байдал, бэлтгэл сургууилт, эрсдлийн төлөвлөгөө, зохион байгуулалтын зураглал, хүний нөөцийн хангалтын бэлэн байдал, эрсдлийн мэдлэг ойлголт, гамшгийн талаарх боловсрол чухал болох нь харагдаж байна.

Япон улс сүүлийн үед гамшгаас сэргийлэх бодлогодоо дараах ойлголт хандлагыг тусгаж, тэдгээрийг цогц байдлаар, зэрэгцүүлэн, уялдаатай авч үзэх шаардлагатай гэж үзэх болжээ. Энэ бол “өөрийгөө аврах” (自助), “бусдад тусалж, бусдыг аврах” (共助), “төр засаг нь иргэдээ аврах” (公助) тухай 3 ойлголт хандлага юм. Ер нь хаа ч тэр томоохон гамшиг эрсдэлээс сэргийлэх, эсвэл гамшиг эрсдэл тохиолдсон үед ард иргэд нь төр засаг, мэргэжлийн байгууллагадаа найдах, тэр асуудлыг даатгаж орхих, эсвэл төр засаг биднийг хамгаалах ёстой гэж туйлшрах хандлагатай байдаг. Тэгвэл япончууд тэрхүү хандлагаа өөрчилж, дээрх 3 ойлголт хандлагыг төр засаг, мэргэжлийн байгууллага, орон нутаг, гэр бүл, иргэдийн дунд, нийгмийн бүх түвшинд бий болгож, ойлгуулах явдал нийгмийг эрсдэлээс авран сэргийлэхэд маш чухал гэж үзэж байна. Энэ нь дээрх сургамж, дүгнэлтээс ч тодорхой харагдаж байна. Япончууд гамшгаас сэргийлэх нийгмийн бэлэн байдлыг хангаж бэхжүүлэхэд нөлөөлөх талаасаа насанд хүрсэн хүнээс илүү хүүхэд чухал үүрэгтэй гэж үздэг. Тиймээс бага насны хүүхдийн боловсролын байгууллагад онцгой анхаарал хандуулдаг бөгөөд дээрх 3 ойлголт хандлагын талаар “гамшгийн боловсрол”-оор дамжуулж ойлгуулан таниулахыг зорьж байна. Өөрөөр хэлбэл, ирээдүйн аав ээж болох хүүхдүүдэд дээрх ойлголт хандлагыг ойлгуулж, зөв хандлагыг хэвшүүлж чадвал гамшгаас сэргийлэх ухамсартай нийгмийг бий болгож бэхжүүлэх ажээ.

4. Дүгнэлт: “Үндэсний Resilience”

“Гамшиг хэлж ирдэггүй, хийсэж ирдэг” гэх маягтай хэллэг бий. Бас хүнд “муу ёр” гээд гамшгийн тухай ярихыг хүсдэггүй зан бий. Хүн төрөлхтөн байгалийн хүчийг захирах тухай ойлголт үеэ өнгөрөөж, харин байгалийн хүчийг хүлээн зөвшөөрөх болсон. Гэвч сүүлийн үед байгалийн гамшгийн эрсдлийн давтамж улам ихсэж байхад, орчин үеийн нийгэм урьд өмнөхөөсөө илүү хэврэг болж байна. Хүн төрөлхтөн “Ковид-19 цар тахал”-аас ихээхэн сургамж авч байна. Томоохон гамшиг эрсдлийн давтамж ихсэж байгаа явдал хүн төрөлхтний санаа зовох асуудал яахын аргагүй мөн. Гамшиг эрсдэл тулгарах үед хөдөлж эхлэх биш, харин ердийн цаг үед ч “гамшиг ирж болно шүү” гэсэн бодлоор хандаж, аливаа гамшиг эрсдэлд байнгын бэлэн байх явдал чухал болж байна.

Ер нь томоохон гамшгаас бүрэн сэргийлэх, хамгаалах асуудалд хязгаар бий. Монголчууд бид томоохон гамшиг эрсдлийн талаар цэгцтэй ойлголт мэдлэг бага, туршлага ч хомс. Тиймээс энэ талаар туршлага хуримтлуулсан улс орнуудаас суралцаж, хамтран ажиллах хэрэгцээ шаардлага бидэнд байна.

Дээр дурдсанчлан, Япон улсын туршлагаас авч үзэхэд, дараах дүгнэлт хийж болох юм. Үүнд:

1. Япончууд түүхэндээ өөрийн гэсэн цогц “гамшгийн (тухай) мэдлэг, соёл”-ыг бүтээж, гамшгийн эрсдлийг даван туулах чадвартай нийгмийг бэхжүүлж иржээ. Гэсэн хэдий ч тэд улс үндэстнийхээ өнөөгийн даван туулах чадвар (*Resilience*)-ыг хангалтгүй гэж үзэж байна. Улс үндэстнийхээ *Resilience* чадварыг сайжруулахын тулд хөгжлийн бодлоготой уялдаа бүхий “Үндэсний *Resilience* (*National Resilience*) бодлого”-ыг гаргаж хэрэгжүүлж байна. Энэ бол уг асуудлыг шийдвэрлэх цогц хандлага ажээ.
2. Япончууд байгалийн хүчийг хүлээн зөвшөөрч, дээдэлдэг үндэстэн. Тэд “гамшгаас хамгаалах”, аль эсвэл “гамшгийг бууруулах” гэхийн оронд “гамшгаас сэргийлэх” гэж, “богино хугацааны эдийн засгийн үр ашгийг чухалчлах”-аас илүү “аюулгүй, амар амгалан нийгмийг байгуулах”-ыг зорьж, *Resilience* чадварын “хатуу” (*hard*) талаас илүү “зөөлөн (*soft*) талыг, аль эсвэл аль алийг нь чухалчилж байна. Өөрөөр хэлбэл япончууд хандлагаа өөрчилж байна.
3. Гамшгаас сэргийлэхэд “гамшгийн (тухай) боловсрол” нэн чухал бөгөөд гамшгаас сэргийлэх тухай нийгмийн ухамсрыг сайжруулахад хүүхдүүд чухал үүрэгтэй оролцогч тал юм.
4. Япон улсын гамшгаас сэргийлэх бодлогод “өөрийгөө аврах” (自助), “бусдад тусалж, бусдыг аврах” (共助), “төр засаг нь иргэдээ аврах” (公助) гэсэн 3 ойлголт хандлагыг цогц байдлаар, зэрэгцүүлэн, уялдаатай авч үзэж тусгасан байна. Түүний зэрэгцээ оролцогч талуудын хоорондох “Эрсдэлийн харилцаа” (*Risk communication*)-г чухалчлан авч үзэж байна.
5. *Resilience* буюу даван туулах чадварыг сайжруулж бэхжүүлэх асуудал бол “Хүний аюулгүй байдал” хийгээд “Үндэсний аюулгүй байдал”-ыг ханган бэхжүүлэх асуудал юм. Япон улсын туршлага, сургамжаас суралцаж, “Үндэсний даван туулах чадвар” (*National Resilience*)-аа бэхжүүлэхэд онцгой анхаарч, энэ чиглэлээрх үндэсний судалгааг дэмжин хөгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжих явдал монголчууд бидний хувьд нэн чухал байна.

Ашигласан ном зүй:

1. С.Баттулга 2021а, Үндэсний даван туулах чадвар: Монгол Улс, УБ, Удам соёл
2. С.Баттулга 2021б, "Монгол Улс: Covid-19, Resilience, Гуравдагч хөрш", "Ковид-19 Дэлхийн шинэ дэг журам", СИРПА ФОРУМ-2020 ЭШ-ний хурлын эмхэтгэл, 10-29, МУИС-ийн ОУХНУС, УБ
3. С.Баттулга 2017, "Үндэсний чадвар болох "Resilience"-ийг сайжруулахын тулд", "Гамшгийн эрсдэл судлал" сэтгүүл, ХСИС, 2(12), 37-45, УБ
4. Сүзүки Ясүхиро 2016, "Нийгмийн Resilience-ийг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтарсан судалгааны үүрэг", XXI зууны Монгол-Японы стратегийн түншлэл: Байгаль орчин, эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаа, Монголын Япон судлалын нийгэмлэгийн хурлын эмхэтгэл, 57-69.
5. Yumiko Nara, Sukhee Battulga 2019a, *"Practical research and Education to enhance Disaster Resilience of Citizens: Lessons from Japan's Disaster and Collaboration with Mongolia"*, The International Science Conference on Strengthening Urban Disaster Resilience, Ulaanbaatar., 2019, 51-61.
6. Yumiko NARA, Sukhee BATTULGA 2019б, *"Observations on Residents' Risk Awareness and Practice of Countermeasures against Natural Disasters in Mongolia: Questionnaire Survey Data of Khovd Citizens"*, Published by Elsevier B.V. Procedia Computer Science 00(2019)000-000, www.sciencedirect.com
7. Francis Fukuyama (2020(2018)), Танигдахуй (*Identity*)), Непко
8. Ulrich Beck (1986) *Risikogesellschaft – Auf dem Weg in eine andere Moderne (Risk Society)*
9. Ulrich Beck (1992) *Risk Society: Towards a New Modernity*. London: Sage, Elisabeth Beck-Gernsheim (1994) *Riskante Freiheiten- Gesellschaftliche Individualisierungsprozesse in der Moderne*,
10. Ulrich Beck (1998) *World Risk Society*. Cambridge: Polity Press, Adam, Barbara & Beck, Ulrich & Van Loon, Joost
11. Ulrich Beck (2000) *The Risk Society and Beyond: Critical Issues for Social Theory*. London: Sage, (2009). *World at Risk*. Cambridge: Polity Press)

12. Tetsuya Inamura, Sukhee Battulga, Shoko Ishii, Hisashi Ichiguro, Yasuhiro Suzuki 2016, "*An interdisciplinary study on resilience in Mongolia: Earthquake damage and active fault*", (モンゴルにおけるレジリエンスに関する学際共同研究—地震被害 活断層調査) Journal of The Open University of Japan, №.34(2016) pp.39-52.
13. Tetsuya Inamura, Yasuhiro Suzuki, Shoko Ishii, Sukhee Battulga, Yumiko Nara, Akinobu Kawai, Tsuneo Yamada, Hirofumi Takahashi 2017, "Research and Activities of the Resilience in Mongolia: Starting the JICA PARTNERSHIP PROGRAM" (モンゴルにおけるレジリエンスの研究と実践—JICA草の根技術協力事業（パートナー型）の開始), Journal of The Open University of Japan, №.35(2017), pp.61-76.
14. Клаус Шваб, Тьерри Маллерет 2021(2020), "Ковид-19: Их сэргэлт" (COVID-19: The Great Reset), United Business Review
15. 奈良由美子, 稲村哲也 2018, 『レジリエンスの諸相—人類学的視点からの挑戦—』放送大学
16. 正林督章 2022「新型コロナウイルス感染症に対する日本政府の対応」保険医療科学 Vol.71 No.4 p.280-291.
17. 林修一郎 2022「新型コロナウイルス感染症に対するワクチン接種事業の全容」保険医療科学 Vol.71 No.4 p.335-345.
18. Yuri Okina 2021 「日本のコロナ対応策の特徴と課題—国際比較の視点から見えてくるもの—」 Opinion Paper, NIRA, No.57/2021.May, p2-11.
19. 奈良由美子 稲村哲也 2018『レジリエンスの諸相—人類史的視点からの挑戦—』放送大学
20. 村木良孝 2015「レジリエンスの統合的理解に向けて」東京大学大学院教育学研究科紀要, 第55巻
21. 林吉嗣 鈴木康弘 2015, 『レジリエンスと地域創生: 伝統知とビッグデータから探る国土デザイン』、明石書店
22. Johns Hopkins Univ. CSSE Covid-19 Data